

ХЯНАЛТАД АВСАН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ
/Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар/

2014 оны 12 дугаар сарын 23

№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хяналтад байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь
1	Ажил дүгнэх тухай 2014.02.04 А/44	4. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэн, идэвх санаачлага гарган, хариуцлага сахилгыг өндөржүүлж, бодлогын зорилт нэг бүрийн бодит үр дүнг ахиулж ажиллахыг нийт удирдлагуудад үүрэг болгосугай.	Зөвлөмжид тусгасан ажлуудыг хэвшил болгон ажиллах	Өгсөн зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ: - “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг албан хаагчдад дахин танилцуулж, тайлан, мэдээний биелэлтийн хувийг журмын дагуу гаргаж байна. -Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандартыг төрийн албан хаагчдад судлуулж, мөрдлөг болгох зорилгоор “Баримт бичгийн стандарт” сэдэвт аяныг байгууллага дээр зохион байгуулж байна. Аяны хүрээнд холбогдох журмуудыг танилцууллаа. -Газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/13 дугаар тушаалаар 2013 онд үрэгдүүлсэн нийт 90 ширхэг хэвлэмэл хуудсыг хүчингүй болголоо. -Байгууллагын цахим хуудсыг шинэчилж, газрын даргын тушаал болон албан хаагчдын мэдээллийг цахим хуудсанд байршуулж, мөн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж байна.	90
2	Налайх дүүрэгт шаврын орд ашиглан	1. Налайх дүүргийн нутаг дэвсгэрт шаврын орд ашиглан, тоосгоны үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нэгдсэн шалгалт хийж, хууль	- Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах	Нийслэлийн Засаг даргын А/151 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг удирдамжийн дагуу хяналт шалгалтыг 2 үе шаттайгаар явуулсан.	100

	<p>тоосгоны үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2014.03.07 А/151</p>	<p>тогтоомжийн дагуу холбогдох хариуцлагын арга хэмжээ авах, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2. Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон шалгалтын дүнг 2014 оны 2 дугаар улиралд багтаан Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Г.Болормаа/-т даалгасугай. 3. Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд даалгасугай.</p>		<p>Шалгалтад Налайх дүүргийн нутаг дэвсгэрт шаврын орд ашиглан тоосгоны үйлдвэрлэл эрхлэгч 29 аж ахуйн нэгж хамрагдахаас 22 аж ахуйн нэгж хамрагдсан. 7 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа явуулаагүй байна. Хяналт шалгалтыг дараах чиглэлүүдээр хийж гүйцэтгэлээ.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгаль орчны хяналтын чиглэлээр, 2. Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр, 3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байранд тавигдах шаардлагын талаар, 4. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр, мөн аж ахуйн нэгжүүдийн эрсдлийг хяналтын хуудсуудаар тодорхойлсон. <p>Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад 2 удаагийн сургалт, семинарыг зохион байгуулж, ном гарын авлагаар хангасан.</p> <p>Шалгалтын дүнг нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, А/635 дугаар захирамжийг гаргасан.</p> <p>Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 21 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан. 15 аж ахуйн нэгж, 1 албан тушаалтанд нийт 15.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч ажилласан.</p>	
--	--	--	--	---	--

3	<p>“Нийслэлийн Мал хамгаалах сан” байгуулах тухай 2014.03.14 A/166</p>	<p>1. Нийслэл дэх Мал хамгаалах сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай. 2. Мал хамгаалах сангийн зөвлөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд даалгасугай. 3. Сангийн ажлыг хагас, бүтэн жилээр тайлагнаж байхыг Мал хамгаалах сангийн зөвлөлийн даргад үүрэг болгосугай.</p>	<p>1.Нийслэл дэх Мал хамгаалах сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулна. 2.Боловсруулсан захирамжийн төслийг Нийслэлийн Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засаг даргын захирамж гаргуулна. 3. Зөвлөлийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг зөвлөлийн даргаар батлуулна.</p>	<p>Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, сангийн зөвлөлийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сангийн данс нээлгэх хүсэлтийг НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. МУ-ын ЗГ-ын 2013 оны 394 дүгээр тогтоолоор батлагдсан үндэсний үйлдвэрт хонь , тэмээний ноос болон арьс ширийг бэлтгэн нийлүүлсэн малчдын мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулж ажиллаа.</p>	90
4	<p>Ажлын хэсэг байгуулах тухай 2014.03.18 A/177</p>	<p>1. Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Нийслэлийн нутаг дэвсгэрт “Байгаль орчинд халгүй үйлдвэрлэл эрхлэх нийтлэг журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. 2. Нийтлэг журмын төслийг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд 2014 оны 2 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд даалгасугай.</p>	<p>- Журмын төсөлд санал авах ажлыг зохион байгуулна - Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулах</p>	<p>Байгаль орчинд халгүй үйлдвэрлэл эрхлэх нийтлэг журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг НЗД-ын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/177 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийг 04 дүгээр сарын 04, 18, 05 дугаар сарын 28-ны өдрүүдэд хуралдуулан, журмын төслийг хэлэлцүүлсний зэрэгцээ холбогдох Төрийн захиргааны төв байгууллагууд, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Мэргэжлийн холбоодоос албан тоотоор саналуудыг авч тусгасан. Мөн журмын төслийг боловсруулахтай холбогдуулан дүүргүүдийн ЖДҮ хариуцсан мэргэжилтнүүдтэй 05 дугаар сарын 08-ны өдөр уулзалт хийж, саналуудыг авч тусгасан. Журмын төслийг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн 06 дугаар 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, зөвлөлийн гишүүдийн саналуудыг нэмж тусган дахин хэлэлцэхээр</p>	90

				<p>ТОГТСОН.</p> <p>Нийтээр дагаж мөрдөх журмыг үйлдвэрлэлийн бүсийн төлөвлөлт, дүүргүүдэд үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл, Улаанбаатар хотын нэгж хорооллуудын төлөвлөлттэй уялдуулан боловсруулахтай холбогдуулан хамтран ажиллах хүсэлтийг НЕТГазарт албан тоотоор хүргүүлээд байна.</p> <p>Төлөвлөлтийн баруун-2 бүсийн төсөл, Үйлдвэр 1-р хорооллын ерөнхий төлөвлөгөө, Төлөвлөлтийн баруун-2 бүсийн төсөл, Үйлдвэр 2-р хорооллын ерөнхий төлөвлөгөө, Үйлдвэр 3-р хорооллын ерөнхий төлөвлөгөөг тус тус боловсруулах тул цаашид хамтран ажиллаж, журмын төслийг уялдуулан боловсруулна.</p>	
5	<p>Улаанбаатар хотод ачаа тээврийн нэгдсэн логистик төв байгуулах тухай 2014.03.18 А/178</p>	<p>1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.2 дугаар заалт, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичигт тусгагдсаны дагуу хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн логистикийн төвийг төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.</p> <p>2. Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй ачаа тээврийн терминалуудын өнөөгийн байдалд аттестатчилал явуулан дүнг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /М.Ням-Очир/,</p>	<p>- Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулах</p>	<p>Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн логистик төвийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулахаар ажлыг зохион байгуулж байна. Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн логистик байгуулах ажлын хүрээнд шийдвэрлэх асуудал, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Ажлын хэсгээс гаргасан саналын дагуу газрын төлбөр болон холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхээр НИТХТ-ийн 2014 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, төлөөлөгчдөөс зарим асуудлыг тодруулах шаардлагатай гэж үзсэн тул дахин хэлэлцэхээр тогтсон.</p> <p>Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 14 ачаа тээврийн терминалуудын</p>	100

		нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.		үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын 2014 оны 04.07-ны өдрийн 02-61-/13 удирдамжийн дагуу хяналт шалгалтыг явуулж, дүнг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.	
6	Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсад томилон ажиллуулах тухай 2014.03.27 А/215	1.Вьетнам Монголын Засгийн газар хоорондын комиссын 15 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн мөрөөр Вьетнам улсын оёдлын үйлдвэрийг паркийн системээр хөгжүүлсэн туршлагаас судлах, даавуун нэхмэлийн үйлдвэр, гутлын үйлдвэртэй танилцаж, туршлага судлах зорилгоор 2014 оны 04 сарын 12-ноос 19-ний өдрүүдэд БНСВУ-д ажлын айлчлал хийх багийн бүрэлдэхүүнд Нийслэлийн Үйлдвэр хөдөө, аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Т.Цэрэндэжидийг оруулж БНСВУ-д томилон ажиллуулсугай. 2.Т.Цэрэндэжидэд холбогдох 1.404.100 /Нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга нэг зуу/ төгрөг, 910/Есөн зуун арав/ ам.доллар Гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй. 3.Томилолтоор явсан тухай тайланг ирснээс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн Удирдлагын зөвлөлд танилцуулж хувийг Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг Т.Цэрэндэжидэд үүрэг болгосугай.	“Оёдол, нэхмэл, гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр” БНСВУ-д Хочимин хотод аж ахуйн нэгж байгууллагуудын туршлага судлах	Монгол Улс, БНСВУ-ын Засгийн газар хоорондын 15 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга С.Рэгзэдмаа тэргүүтэй оёдол, ноос, ноолуурын салбарын нийт 28 хүний бүрэлдэхүүнтэй баг 4 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд БНСВУ-д ажлын айлчлал хийлээ. Уг бүрэлдэхүүнд НҮХААГ-ын Үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Цэрэндэжид орж ажиллав. Монголын төлөөлөгчид БНСВУ-н хөнгөн үйлдвэрийн салбарын бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдтэй харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэх, оёдол, нэхмэл, гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр Хочимин хотын пүүс, компаниудын үйл ажиллагаа, туршлагатай танилцлаа.	100
7	Ажлын хэсэг байгуулах тухай	1. Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотыг 2020 он	- НЗД-ын 2002 оны 411 дүгээр захирамжийг шинэчлэн ажлын хэсэг байгуулна.	Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Бат-Эрдэнэ даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт Нийслэлийн	100

	2014.04.07 A/260	<p>хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан “Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэд аж ахуйн нэгж, байгууллагаас мал аж ахуй эрхлэх журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.</p> <p>2. Журмын төслийг Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд 2014 оны 2 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн дарга Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд даалгасугай.</p>	<p>- Боловсруулсан журмын төслийг Нийслэлийн Удирдлагын Зөвлөлийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулна.</p>	<p>Өмчийн харилцааны газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүргээс төлөөлөл орсон.</p> <p>Журмын төслийг Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, "Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам" Нийслэлийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/451 дүгээр захирамжаар батлагдсан.</p>	
8	<p>Бүгд Найрамдах Австри улсад туршлага судлах тухай 2014.04.09 A/281</p>	<p>1.Бүгд найрамдах Австри улсын Хөдөө аж ахуйн салбарын дэвшилтэт техник, технологитой танилцах, туршлага судлах, хамтран ажиллах зорилгоор Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн, Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хамтын ажиллагааны хэлтсийн Австрийн төслүүд хариуцсан мэргэжилтэн Р.Эрдэнэ нарыг 2014 оны 04 дүгээр сарын 20-ноос 30-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод томилон явуулсугай.</p> <p>2.Төлөөлөгчдийн холбогдох зардлыг Гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.</p> <p>3.Туршлага судалсан тухай тайланг ирсэнээс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн Удирдлагын Зөвлөлийн хуралд</p>	<p>Дунд оврын тоног төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэх паркийн талаар судлан, бий болгох боломжийг гаргах</p> <p>Жилийн дөрвөн улиралд зохицсон техникийн төлбөрт үйлчилгээг нарийвчлан судлах</p> <p>Эрсдэлийн талаар судлах</p> <p>Техник дундын үйлчилгээний төвийн өөрийн орны нөхцөлд тохирсон менежментийн загварыг гаргах</p>	<p>Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн, Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хамтын ажиллагааны хэлтсийн Австрийн төслүүд хариуцсан мэргэжилтэн Р.Эрдэнэ нар нь Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод томилолтоор ажлаад ирсэн. Айлчлал хамтын ажиллагааны хүрээнд Австри Монголын “Очир” нийгэмлэгийн ерөнхийлөгч Dr.Franz Greif Raumberg-Gumpenstein-ны сургалт, судалгааны төв, Вена хотын Газар тариалан, хүрээлэн буй орчны багшийн дээд сургууль, “Puhra” ХАА-н мэргэжлийн, Обер-Австри мужийн ХАА-н танхим, ХАА, ойн ажилчдын клуб, Halbturm-ны Газар тариалан, худалдааны компани, Австрийн ХАА-н техникийн удирдлагын зөвлөл, Munchhof дахь ХАА-н</p>	100

		танилцуулж, хувийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг Г.Пүрэвсүрэнд даалгасугай.		машин механизм, гагнуурын аж ахуй, Hannes Niedermayer-ийн Биоферм зэрэг ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, их дээд сургууль болон бизнес хүмүүстэй уулзсан. Томилолтоор ажилласан тухай тайланг Гадаад харилцааны хэлтэст хүргүүлж, Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.	
9	Журам батлах тухай 2014.04.09 А/237	1. "Нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн санг хөтлөн эрхлэх журам"-ыг нэг, "Нэгдсэн санд оруулах захирамжлалын баримт бичгийн хязгаарлалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ё.Гэрэлчулуунд/-т, журмын биелэлтийг хангаж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.	- Захирамжлалын баримт бичгийг бүртгэлийн дэвтэр нээн бүртгэх, - Захирамжлалын баримт бичиг бүрэн эхээрээ албажсан тухай огноог тэмдэглэж, дарааллын санд төвлөрүүлэн хадгалах, - Захирамжлалын баримт бичгийг журманд заасны дагуу ангилан олон нийтэд нээлттэй ил тод болгох,	Захирамжлалын баримт бичгийг бүртгэлийн дэвтэр шинээр нээн, баримт бичгийг бүртгэн ажиллаж байна. Захирамжлалын баримт бичиг бүрэн эхээрээ албажсан тухай огноог тэмдэглэж, дарааллын санд төвлөрүүлэн хадгалж байна. Захирамжлалын баримт бичгийг журамд заасны дагуу ангилан олон нийтэд нээлттэй ил тод болгох ажлын хүрээн байгууллагын цахим хуудсанд шинэ цэц үүсгэн байршуулан ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын баталсан "Хууль таны хөтөч" уралдааны удирдамжийн дагуу 2005-2013 онуудад гарсан газрын даргын тушаалудад ангилал, өөрчлөлт /кодификаци/ хийж гүйцэтгэлээ. Кодификаци хийсэн баримт бичгийг сканердаж байгууллагын цахим хуудаст орууллаа.	100
10	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот томилолтоор явуулах тухай 2014.05.06 А/365	1.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ тэргүүтэй, нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн,	ӨМӨЗО-ны Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах боломжийг судлах	БНХАУ-ын Чень И-Хөх хотын дарга, Ган-бөх- Хөх хотын орлогч дарга, Фань Айжи-Хөх хотын Хөдөө аж ахуйн газрын дарга, Гө Чэнган-Хөх хотын Худалдааны газрын дарга, Ли Гүнгэ- Хөх хотын Гадаад харилцааны газрын орлогч дарга нар болон албаны бусад хүмүүстэй уулзлаа.	100

		<p>нийслэлийн Мал эмнэлэгийн газрын дарга А.Нарантуяа, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга М.Ням-Очир, нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн дарга Д.Одгэрэл нарыг 2014 оны 05 дугаар сарын 12-ноос 16-ны өдрүүдэд томилон явуулсугай.</p> <p>2.Төлөөлөгчдийн холбогдох зардлыг хавсралтаар баталж, Гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.</p> <p>3.Албан томилолтын тайланг ирснээс хойш долоо хоногийн дотор Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, хувийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг Г.Пүрэвсүрэнд даалгасугай.</p>		<p>Хөх хотын Ардын засгийн газрын удирдлага хүлээн авч, талууд хамтран ажиллах боломжийн талаар санал бодлоо солилцов.</p> <p>Хөх хотын Хөдөө аж ахуйн газарт зочилж, Нийслэлийн иргэдийн сүүний хангамжийг сайжруулах зорилгоор сүүний чиглэлийн 250 үнээний ферм байгуулах талаар хүсэлт тавьж, танилцуулга хийгдсэн.</p> <p>Мөн хүлэмжийн аж ахуй, мөөгний аж ахуй, мал эмнэлэг болон мэргэжлийн хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулаах хүсэлт тавьсан. Хүнсний бүтээгдэхүүний болон эмийн хяналтын удирдлагуудтай уулзалт хийж, Сайхан дүүргийн хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо, зэрэг газар тариалангийн үйл ажиллагаатай танилцав.</p> <p>Мөн сүүний чиглэлийн 10 000 үнээний Сайхан фермийн үйл ажиллагаатай танилцав.</p> <p>Хөх хотын Худалдааг дэмжих нийгэмлэгийн удирдлагуудтай уулзаж мэдээлэл солилцлоо.</p> <p>ӨМӨЗО-ы Мэнцоканхан цөлжилтийн эсрэг өвс модны үржүүлэг, судалгааны төв, Хөх хотын Мэн ню сүүний үйлдвэр, Махны чиглэлийн хонины аж ахуйн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа.</p> <p>ӨМӨЗО-ны Багшийн Их сургуультай Санамж бичиг зурах үйл ажиллагааг зохион байгуулж сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа.</p> <p>Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв Өвөрмонголын Багшийн Их сургуулийн хооронд хамтран ажиллах Санамж бичиг байгуулж гарын үсэг зурлаа.</p>	
--	--	---	--	--	--

11	<p>Журам шинэчлэн батлах тухай 2014.06.02 A/279</p>	<p>1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад мөрдөн ажиллах "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ыг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, захирамжлалын баримт бичгийн төсөлд санал авах хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.</p>	<p>Журмыг мөрдлөг болгон ажиллах</p>	<p>Журмыг нийт албан хаагчдад танилцуулж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	100
12	<p>БНАУ-ын Вена хотод томилолтоор ажиллуулах тухай 2014.06.18 A/509</p>	<p>1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Вена хотод айлчлахтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд, Гадаад харилцааны хэлтсийн дарга Д.Наранцэцэг, нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн нарыг 2014 оны 06 дугаар сарын 21-нээс 25-ны өдрүүдэд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хамтын ажиллагааны хэлтсийн Австрийн төслүүд хариуцсан мэргэжилтэн Р.Эрдэнийг 2014 оны 06 дугаар сарын 21-нээс 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд томилон ажиллуулсугай. 2. Төлөөлөгчдөд холбогдох зардлыг хавсралтаар баталж, гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй. 3. Томилолтоор ажилласан тухай тайланг ирснээс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Д.Наранцэцэгт үүрэг болгосугай.</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Вена хотод хийх албан айлчлал, Улаанбаатарт хот орчимд эрчимжсэн фермийн аж ахуйг хөгжүүлэх талаар судалгаа явуулах, "Улаанбаатар хотын иргэдийн хүсний хангамжийг сайжруулах" төслийн концепци боловсруулах талаар санал солилцох, санамж бичигт гарын үсэг зурах</p>	<p>Монгол улсын нийслэл Улаанбаатар хот, Австри - Монголын нийгэмлэг /хамтад нь талууд гэх/- тэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалт болон Улаанбаатарт хот орчимд эрчимжсэн фермийн аж ахуйг хөгжүүлэх талаар судалгаа явуулах, "Улаанбаатар хотын иргэдийн хүсний хангамжийг сайжруулах" төслийн концепци боловсруулах талаар санал солилцон, дараах чиглэлээр хамтран тохиролцов. А.Хамтын ажиллагааны чигтгэл: <ul style="list-style-type: none"> Улаанбаатар хотын иргэдийн хүсний хангамжийг сайжруулах төслийн урьдчилсан судалгааны ажлыг гүйцэтгэх, /энэхүү судалгааны ажлын зорилго нь нийслэлийн иргэдийг дотоодын хүнсээр ялангуяа сүү, сүүн бүтээгдэхүүнээр найдвартай хангах үндсэн шаардлагуудыг тодорхойлоход оршино/ Сүүний чиглэлийн үнээний саалийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор тухайн бүс нутагт өвс тэжээл, ногоон даршны нөөцийг нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийх, Тэжээлийн үр, бордоо, хөдөө аж ахуйн </p>	100

				<p>техник технологи, сургалт, санхүүжилт зэрэг малчид, хоршоодод шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх гарцыг судлах,</p> <ul style="list-style-type: none"> • Хоршоодын бүтээгдэхүүнийг дангаараа болон бусад аж ахуйн нэгжтэй хамтран боловсруулах, борлуулах болон сурталчлах ажлыг зохион байгуулах <p>Нийслэлийн хэмжээнд дунд оврын хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж бүхий техник дундын үйлчилгээний төв" байгуулах талаар судлах</p>	
13	<p>Ажлын удирдамж, санхүүжилт батлах тухай</p> <p>2014 оны 08 сарын 15 өдөр А/708</p>	<p>1.Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн дүүргүүдэд үржүүлж буй үхэр сүргийг үүлдэрлэг байдал, ашиг шимийн чиглэлээр ялган баталгаажуулах, ангилалт, тооллого хийх мэргэжлийн багийн бүрэлдэхүүн, ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, ажиллах төсөв зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.</p> <p>2.Нийслэлд үржүүлж буй үхэр сүргийн үүрдэрлэг байдалд ангилалт хийх ажилд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Т.Бат-Эрдэнэ/, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Пүрэвсүрэн/, Дүүргийн засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>1.Нийслэлийн Засаг даргын захирамж гаргуулах.</p> <p>2. Ажлын удирдамж батлуулах.</p> <p>3. Ангилалт хийх ажлын хэсэгт семинар хийж удирдамжинд заасны дагуу мал бүхий 9 дүүрэгт хяналтын хэмжилт хийж ажиллах.</p>	<p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 05 сарын 01-ны өдрийн А/151 тоот тушаал, Нийслэлийн засаг даргын А/708 дугаар захирамж батлагдсан ажлын удирдамжийг хэрэгжүүлэх ажлаар мал бүхий 9 дүүрэгт ажиллав.</p> <p>2013 оны жилийн эцсийн мал тооллогын дүнд үндэслэн дүүргүүдэд үржүүлэгдэж буй үүлдэр, сүүний чиглэлийн үнээний тархалт, тоо толгойг тооллогын маягтын дагуу гаргаж, тэдгээрийн эрлийз, сайжирсан малын тоог гарган, үүлдэрлэг байдлыг тодорхойлов.</p> <p>Мэргэжлийн багийн тооллогын дүнгээр нийт 31446 толгой сүүний болон хосолмол ашиг шимт үнээнд ангилалт хийв.</p> <p>Нийт ангилалтанд хамрагдсан үнээний 40 орчим хувь нь хар тарлан, алатау, симментал цэвэр үүлдрийнх, бусад нь эдгээрийн болон нутгийн монгол, Казакын Цагаан Толгойгийн ямар нэгэн цус оролцсон эрлийз байна. Сүүний чиглэлийн шилмэл үүлдрийн үхэр болон түүгээр сайжирсан малын фото зургийг авч баталгаажуулав.</p>	100

14	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай 2014.08.20 А/718</p>	<p>2.Төрийн зарим үйлчилгээг 2014 онд онлайн хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж тэргүүн ээлжинд хэрэгжүүлэхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Б.Бадрал/, нийслэлийн Архивын газар /С.Гаваа/-т, нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар /Г.Болормаа/, нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар /Н.Нацагдорж/, нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/, нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Б.Байгальмаа/, нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.</p>	<p>-захирамжлалын баримт бичгийг “UBLEGAL.MN” сайтанд оруулах -ажлыг хэвшүүлж, мөрдөн ажиллах</p>	<p>“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагаас иргэд, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “UBLEGAL.MN” цахим хуудсанд 1993-2013 онд байгууллагаас гарсан захирамжлын баримт бичгийг бүрэн оруулсан ба 2014 онд гарч байгаа газрын даргын тушаалуудыг тухай бүрд нь оруулж байна.</p>	100
15	<p>Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай 2014 оны 09 сарын 19 өдөр А/795</p>	<p>1. “Намрын ногоон өдрүүд-2014” нэгдсэн арга хэмжээний хүрээнд үржлийн шилмэл мал шалгаруулах “Шилмэл мал-2014” улсын үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулж, Нийслэлийн шилмэл мал, тэжээвэр амьтны судалгааг гарган оролцуулахыг нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т даалгасугай. 2. 3. Нийслэлд “Шилмэл мал-2014” улсын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажилд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т. Бат-Эрдэнэд даалгасугай.</p>	<p>1. Нийслэлийн Засаг даргын захирамж гаргуулах. 2. Нийслэлийн мал бүхий дүүргүүдээс оролцох мал болон малчдыг бүртгэх. 3. Нийслэлээс тэжээвэр амьтны төрөлд оролцох амьтныг бүртгэх. 4. Удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах.</p>	<p>Арга хэмжээний үндсэн зохион байгуулагчаар Малын удмын сангийн үндэсний төв, Нийслэлийн Үйлдвэр хөдөө, аж ахуйн газрын Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс оролцлоо. “Шилмэл мал-2014” улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаанд Нийслэлийн 6 дүүргийн 30 иргэн, 30 аж ахуйн нэгжийн 105 мал, амьтан оролцсоноос: адуу 5 толгой, тэмээ 2 толгой, үхэр 14 толгой, хонь 30 толгой, ямаа 1 толгой, мах-өөхний чиглэлийн гахай 20 толгой, өндөглөгч тахиа 16 толгой байснаас гадна галуу, цацагт хяруул, бөдөн, туулай, тагтаа, усан гахай, хоточ банхар, цацагт хяруул зэрэг амьтад, мал аж ахуйн тоног хэрэгсэл, малын эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ танилцуулгыг хийлээ. Нийслэлээс оролцогчдоос “Шилдэг</p>	100

				<p>номинаци"- ийн шагналд СХД-ийн иргэн Б.Төмөрбаатарын хар тарлан үнээ, “Шилмэл хээлтэгч”-ээр СХД-ийн иргэн Д.Давгацэрэнгийн хар тарлан үнээ, СХД-ийн иргэн 32-р хорооны Ч.Энхтуяагийн том цагаан үүлдрийн мэгж, “Шилмэл хээлтүүлэгч”-ээр БЗД-ийн иргэн А.Баярбаатарын алатау бух, БЗД-ийн 20-р хорооны иргэн Болдбаатарын иоркшир үүлдрийн бодон, “Тусгай байр”-ын шагналд ХУД-ийн иргэн Н.Баттөмөрийн хар алатау “Түмэн шувуут” ХХК байгууллагаараа оролцон “Шилдэг оролцогч аж ахуйн нэгж”-ээр тус тус шалгарч гойд ашиг шимт мал, амьтанд бүртгэгдлээ.</p>	
16	<p>БНСУ-Д Сургалтад хамруулах тухай 2014.10.16 А/879</p>	<p>1.Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрийн хэлтсийн мэргэжилтэн Б.Ганцэцэгийг БНСУ-ын Тэжон хотноо зохион байгуулагдах “Шинжлэх ухаан, технологийн парк” сэдэвт бизнес сургалтад оролцуулахаар 2014 оны 10 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 07-ны өдрүүдэд томилон явуулсугай. 2.Холбогдох зардал болох 950 000 /Есөн зуун тавин мянга/ төгрөгийг гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй. 3.Сургалтад хамрагдсан тухай тайланг ирснээс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг Б.Ганцэцэгт даалгасугай</p>	<p>“Шинжлэх ухаан технологийн паркийн хөгжил” сургалт, семинар</p>	<p>БНСУ-ын Даежеон хотноо болсон “Шинжлэх ухаан, технологийн паркийн хөгжил” сэдэвт 13 дахь удаагийн 11 хоногийн сургалтад 17 орны 23 оролцогчид хамрагдсан. Нийт 11 удаагийн лекц, семинар орсон ба тухайн хичээлтэй холбогдолтой уулзалт, аялалууд зохион байгуулагдсан. Сургалтад хамрагдсанаар Солонгос улсын бүсийн болон бүсийн инновацийн систем, үйлдвэрлэлийн шинэ бодлого, технологийг эдийн засгийн эргэлтэд оруулах, шинжлэх ухаан технологийн паркийн хөгжлийн стратеги, бизнес төлөвлөгөө зэрэг сэдвүүдээр Солонгос улсын туршлагаас суралцан, хэрхэн Шинжлэх ухаан технологийн парк үүсч хөгжсөн, ямар ямар бэрхшээл тулгарсан, мөн хэрхэн давж гарсан болон ШУТПаркийг хэрхэн байгуулах талаарх мэдээ мэдээллийг олж авсан.</p>	100
17	Богино	1.Нийслэлийн Засаг даргын Тамгын	“Байгаль орчны шинжлэх ухаан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,	100

	<p>хугацааны сургалтад хамруулах тухай 2014.10.10 А/861</p>	<p>газрын захиалгаар Япон улсын Цукуба Их сургуулиас зохион байгуулах “Байгаль орчны шинжлэх ухаан-Тогтвортой байгаль орчин” сэдэвт сургалтад хамрагдах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар баталж, 2014 оны 10 дугаар сарын 13-наас 25-ны өдрүүдэд томилон явуулсугай. 2.Сургалтын зардалд шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталж, Нарийн мэргэжлээр гадаадын өндөр хөгжилтэй орнуудад боловсон хүчин бэлтгэх зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй. 3.Сургалтад хамрагдсан тухай тайланг ирснээс хойш 14 хоногийн дотор Тамгын газрын Нутгийн захиргааны удирдлагын хэлтэс, Гадаад харилцааны хэлтэст тус тус ирүүлэхийг Д.Баялагцэнгэлд даалгасугай</p>	<p>- Тогтвортой байгаль орчин” сургалт</p>	<p>Байгаль, орчин ногоон хөгжлийн газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Ерөнхий төлөвлөгөөний газар, Өмчийн харилцааны газрын 7 албан хаагч Цукубагийн их сургуулийн Байгаль орчны шинжлэх ухааны сургуульд “Байгаль орчны шинжлэх ухаан-Тогтвортой байгаль орчин” сэдэвт сургалтад 2014 оны 10 дугаар сарын 13-наас 25-ны өдрүүдэд хамрагдсан. Богино хугацааны сургалтаар Япон улсын байгаль орчны бохирдлын түүх;</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчны микробиологи /хөрс цэвэршүүлэх биологийн болон ургамлын нөхөн сэргээлт/; • Цаг уурын өөрчлөлт; • Хог хаягдлын менежмент; • Байгаль орчны удирдлага; • Бодлого төлөвлөгчдийн байгаль орчны ёс зүй; • Биологийн нөөцийн дахин боловсруулалт, ашиглалт; • Байгаль орчны боловсролыг хүүхдэд олгох нь; <p>Зэрэг чиглэлээр судалж, мэргэжил дээшлүүлсэн.</p>	
--	---	--	--	--	--